



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 30 өдөр

Дугаар А/741

Ховд

Зарим байгууллагуудын ажиллах
цагийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын “а”, “л”, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.8, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалт, Засгийн газрын 2020 оны 178 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын хуралдааны 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 34 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэл Улаанбаатар хотод Коронавируст халдвар /Ковид-19/ цар тахлын тохиолдол бүртгэгдсэнтэй холбогдуулан Засгийн газрын 2020 оны 178 дугаар тогтоолын хавсралтад дурдагдсан байгууллагууд болон улсын онцгой комиссоос баталсан хязгаарлалтанд үл хамаарах байгууллагуудаас бусад аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын ажиллах цагийн хуваарийг тогтоосон аймгийн Засаг даргын 2020 оны А/697 дугаар захирамжийн хэрэгжилтийг сунгасан аймгийн Засаг даргын А/703 дугаартай захирамжийн хэрэгжилтийг 2020 оны 12 дүгээр сарын 01-ний өдрийн 06:00 цагаас 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 06.00 цаг хүртэл сунгасугай.

2.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэн сурталчилж ажиллахыг сумдын Засаг дарга нар, Цагдаагийн газар /цагдаагийн хурандаа Э.Даваасүрэн/, Мэргэжлийн хяналтын газар /П.Эрдэнэчулуун/, аж ахуйн нэгж, байгууллагуудын удирдлагуудад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



Zax A/741 Ch
02.3422